



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2021 оны 03 сарын 26 өдөр

Дугаар 05

Хэрлэн сум

Г Компанийн 2020 оны үйл ажиллагааны үр
дүнгээр цалин олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.17 болон “Ажилтнуудад цалин хөлс, нэмэгдэл олгох журам”-ын 4.2.1 дэх заалт, Эрчим хүчний сайдын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/12 тоот тушаал, Эрчим хүчний сайдын 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн а/913 тоот удирдамж, Төлөөлөн удирдах зөвлөлийн Цалин, урамшууллын хорооны 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2020 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн биелэлтийг харгалзан компанийн ажилтнуудад жилийн үйл ажиллагааны үр дүнгээр олгох цалинг батлагдсан цалингийн сангийн хэмжээнд олгохыг Гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д зөвшөөрсүгэй.
2. Компанийн ажилтнуудад жилийн үйл ажиллагааны үр дүнгээр олгох цалингийн хувь хэмжээг ажлын хариуцлага, сахилга бат, ажлын бүтээмж, үр чадвар, жилийн ажлын гүйцэтгэлийг харгалзан олгохыг Гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Ш.Дуламсүрэн/, Цалин, урамшууллын хороо /Г.Пүрэвдорж/-нд тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  Д.БАТЗОРИГ



580020017